



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 11 сарын 29 өдөр

Дугаар А/716

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3."б", Засгийн газрын 2018 оны "Атрын 60 жил бүтээлч ажил өрнүүлэх тухай" 76 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 09/02 дугаар тогтоолоор батлагдсан аймгийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 2.2.4.19, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны "Ой тэмдэглэх тухай" 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Атар газар эзэмшиж, газар тариаланг бие даасан салбар болгон хөгжүүлсний 60 жилийн ойн баярын хурал, хаалтын арга хэмжээг 2019 оны 12 дугаар сарын 04-ний өдөр Арвайхээр суманд зохион байгуулсугай.

2. Ойн түүхэн ном хэвлүүлэхэд 5 800 000 (таван сая найман зуун мянга) төгрөг, баярын хурал зохион байгуулах арга хэмжээний зардалд 3 300 000 (гурван сая гурван зуун мянга) төгрөг, хүндэт зочдод дурсгалын зүйлс хадгалуулахад 2 000 000 (хоёр сая) төгрөг, хүндэтгэлийн хүлээн авалтад 6 000 000 (зургаан сая) төгрөгийг тус тус хавсралтаар баталсугай

3. Хавсралтад тусгагдсан 17 100 000 (арван долоон сая нэг зуун мянга) төгрөгийг аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011101369

Аймгийн Засаг даргын 2019 оны 11 дугаар сарын 29 ны өдрийн 49 дугаар захирамжийн хавсралт

АТАР ГАЗАР ЭЗЭМШИЖ, ГАЗАР ТАРИАЛАНГ БИЕ ДААСАН САЛБАР БОЛГОН ХӨГЖҮҮЛСНИЙ 60 ЖИЛИЙН ОЙН ХҮНДЭТГЭЛИЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДЛЫН ЖАГСААЛТ

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо	Нэг бүрийн үнэ /төг/	Бүгд үнэ төг
1. Түүхэн ном					
1	Аймгийн газар тариалангийн салбарын түүхэн ном	ш	500	11600	5800000
Дүн					5800000
2. Баярын хурал, концерт зохион байгуулах арга хэмжээний зардал					
1	Анонс /Дэлгэц /	м2	48	6666.66	320000
2	Урилга, хөтөлбөр	ш	250	2000	500000
3	Цэцэг өргөх ёслолын тууз, хөгжимчдийн унааны зардал		1	80000	80000
4	Зочид төлөөлөгчдийг хүлээн авч байрлуулах зочид буудлын зардал	20 хүн 2 хоног	40	40000	1600000
5	Хүндэтгэлийн концертын хувцас хэрэглэгдэхүүн	1цаг 20 минут	1	800000	800000
Дүн					3300000
3. Дурсгалын зүйлс					
1	Атар-60 аймгийн түүхийн баримтат киног CD хуулж олшруулах	ш	500	2500	1250000
2	Тариан түрүү	ш	250	1000	250000
3	Уут	ш	250	2000	500000
Дүн					2000000
4. Хүндэтгэлийн хүлээн авалт					
1	Хүндэтгэлийн хүлээн авалт	Хүн / төг	250	20000	5000000
2	Ахмадын өргөөний түрээсийн зардал	1 өдөр	1	400000	400000
3	Хүндэт зочдын хоолны зардал	20 хүн 2 удаа	40	10000	400000
4	Бусад зардал				200000
ДҮН					6000000
Нийт дүн					17100000